

**УВС ЧАЦАРГАНА ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар \_\_\_\_\_

Улаанбаатар хот

**Г“УВС ЧАЦАРГАНА” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит**

**Хурлыг зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2024 оны 3 дугаар сар 13-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн санал хураалтын дүн, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Энгельсийн гудамж, Нарны гүүр “Эн Би Би Ди” ХХК-ийн байрны 2 давхарт хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

- Компанийн 2023 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Бусад асуудал

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2024 оны 03 дугаар сарын 31-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /С.Ариунсанаа/-г гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- |                |                                       |
|----------------|---------------------------------------|
| • С.Ариунсанаа | хурал зохион байгуулах комиссын дарга |
| • С.Ариунсанаа | тооллогын комиссын дарга              |
| • Ц.Сарантуяа  | гишүүн                                |
| • Д.Батбаяр    | гишүүн                                |

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссд даалгасугай.

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /С.Ариунсанаа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

 /Д.ЭРДЭНЭ/